



МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ

2025 оны 12 дугаар сарын 31

Дугаар ББГ.2025/02-545 Улаанбаатар хот
МХ 25-05

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1 хаягт байрлах 9081739 тоот регистрийн дугаартай Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид "Хадгалуулагч" гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай 5, Голомт банкны төв байр хаягт байрлах, 9007001012 тоот улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай, 2075377 тоот регистрийн дугаартай Голомт банк (цаашид "Хадгалагч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 454 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг тус тус удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтээр түүний мөнгөн хөрөнгийг хадгалах, түүнийг хадгалуулагчид буцаан төлөх, мөнгөн хөрөнгийн хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Мөнгөн хадгаламжийн нөхцөл

2.1.Хадгалуулагч тэтгэврийн нөөц сангийн 49,164,369,000.0 (дөчин есөн тэрбум нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга) төгрөгийн мөнгөн хадгаламж (цаашид "Хадгаламж" гэх)-ийг 12 сарын хугацаатай (жилийн суурь хоног 365), жилийн 15.11 (арван тав зууны арван нэг) хувийн хүүтэй Голомт банкн дахь хадгалуулагчийн хадгаламжийн MN220015008125103230 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар хадгалуулна.

2.2.Энэхүү гэрээгээр тохирсон хүүг мөнгөн хөрөнгө хадгаламжийн дансанд шилжин орсон өдрөөс эхлэн хуримтлуулан тооцож, хадгалагч тухайн сарын хадгаламжийн хуримтлуулсан хүүг сар бүрийн сүүлийн өдөр хадгалуулагчийн 4.2.2-т заасан дансанд бүрэн шилжүүлнэ.

2.3.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө тодорхой дүнгээр зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 өдрийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчид зарлага гарсан сарын зарлагадсан мөнгөн дүнд тооцох хүүг 5 хувиар бууруулж, 10.11 хувиар бодох ба үлдэх хадгаламжийн мөнгөн дүнд энэ гэрээний 2.1-д заасан 15.11 хувиар хүүг хуримтлуулан тооцож олгоно.

2.4.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1, 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хадгалагчийн Монголбанкн дахь 3501015 тоот харилцах данснаас хадгалуулагч үл маргах журмаар суутган авна.

2.5.Гэрээний хугацаанд хадгалагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ буурч хадгалуулагчийн байршуулсан хадгаламжийн дүн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтэрсэн тохиолдолд хадгалагч нь мөнгөн хадгаламжийн зөрүүг хүүгийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар хадгалуулагчаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийн дагуу зарлагын гүйлгээ хийнэ. Энэ нь хадгаламжийн хүү буурах үндэслэл болохгүй.

2.6.Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд талуудын тохирсон хүүгийн хэмжээ хэвээр мөрдөгдөнө.

2.7.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд давхар болон илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ.

Гурав.Хадгалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хадгалуулагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1.1.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээллийн дагуу хадгалуулагч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах;

3.1.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалагчаас шаардах;

3.1.3.Сар бүрийн эцэст хуримтлуулсан хүүгийн мэдээллийг авч байх;

3.1.4.Хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.5.Мөнгөн хадгаламжийн дансны гүйлгээ, үлдэгдэл, хүүгийн бодолтыг тулган шалгах;

3.1.6.Хадгалуулагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь авах;

3.1.7.Хадгалуулагч нь хадгалагч банкны Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авах;

3.1.8.Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацааны эцэст өөрийн мөнгөн хадгаламжийг үл маргах журмаар эргүүлэн авах.

3.2.Хадгалуулагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1.Хадгаламжийн гэрээнд заасан хугацаанд хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулах;

3.2.2.Хадгаламжийн данс ашиглан төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

3.2.3.Хадгалагчийн нууц мэдээллийг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

3.2.4.Хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос 15 хоногийн өмнө хугацааг сунгах эсэх талаар мэдэгдэх;

3.2.5.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх;

3.2.6.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалуулагч үл маргах журмаар эргүүлэн төлөх;

3.2.7.Хадгалуулагчийн албан ёсны нэр, мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээд, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд хадгалагчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх;

3.2.8.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээний улмаас данс андуурч гүйлгээ хийсэн тохиолдолд банканд нэн даруй мэдэгдэх.

Дөрөв.Хадгалагчийн эрх, үүрэг

4.1.Хадгалагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1.Хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалуулагчаас шаардах;

4.1.2.Хадгалуулагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.3.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу данс болон гүйлгээний талаар мэдээллийг шаардах;

4.1.4.Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн хадгалуулагчийн дансанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг төлөхийг шаардах.

4.2.Хадгалагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн 49,164,369,000.0 (дөчин есөн тэрбум нэг зуун жаран дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга) төгрөгийн мөнгөн хадгаламжийг хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн гэрээний хугацаа дуусгавар болох сүүлийн өдөр 4.2.2-т заасан харилцах дансанд шилжүүлэх;

4.2.2.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хуримтлуулсан хүүгийн орлогыг Голомт банкн дахь хадгалуулагчийн тэтгэврийн нөөц сангийн MN720015008125102621 тоот дансанд сар бүрийн сүүлийн өдөр бүрэн шилжүүлэх;

4.2.3.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв тооцох;

4.2.4.Хадгалагч өөрийн буруугаас үүдэн хийсэн алдаатай гүйлгээг залруулах болон банкны ажилтны буруугаас хадгалуулагчид хохирол учруулсан бол уг хохирлыг нөхөн төлөх;

4.2.5.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн данснаас энэхүү гэрээний 2.3-т заасан нөхцөл үүссэн үед хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ;

4.2.6.Хадгалуулагчийн дансны нууцыг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

4.2.7.Хадгалагч нь дараах мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор хадгалуулагчид ирүүлнэ. Үүнд:

4.2.7.1.Сарын санхүүгийн байдлын тайлан (IFRS-д нийцсэн), орлогын дэлгэрэнгүй тайлан;

4.2.7.2."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам"-ын дагуу Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлт, хувьцааны үнэ ханшийн хэлбэлзэл, олгосон зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, олон улсын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон эсэх зэрэг мэдээлэл;

4.2.7.3.Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг шилжүүлсэн дансны хуулга;

4.2.7.4.Бусад шаардлагатай мэдээлэл;

4.2.8.Хадгалагчийн эцсийн өмчлөгч болон удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд хадгалуулагчид даруй мэдэгдэх;

4.2.9.Хадгалагч нь "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авахыг хадгалуулагчид зөвшөөрнө.

Тав.Талуудын хариуцлага

5.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1-д заасан үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, мөнгөн хадгаламжийн хүүг алдангийн хамт үл маргах журмаар олгоно;

5.2.Хадгалагч энэхүү гэрээний 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, хадгаламжийн хүүг алдангийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар олгоно;

5.3.Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, эсхүл нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна;

5.4.Талууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

Зургаа.Баталгаа

6.1.Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар хадгалагчийн гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан гэрээний нөхцөлүүдийг биелүүлэх тухай байгууллагын шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.

6.2.Хадгалагч нь гэрээний дагуу хариуцлагыг хүлээх хангалттай мөнгөн хөрөнгийн эх үүсвэртэй байна.

6.3.Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрсдийн олж мэдсэн, тухайн байгууллагын холбогдох мэдээ мэдээлэл, баримт бичгийн нууцыг харилцан чанд хадгална.

Долоо.Гэрээ дуусгавар болох, цуцлах

7.1.Энэхүү гэрээний 2.1-д заасан үндсэн хугацаа дууссан, гэрээг 7.2-т заасан үндэслэлээр цуцалснаар дуусгавар болно.

7.2.Гэрээг дор дурдсан нөхцөлөөр хугацаанаас нь өмнө цуцалж, энэ талаар 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Гэрээг цуцлахад энэхүү гэрээний 2.3 дахь хэсэг хамаарахгүй.

7.2.1.Хадгалагч нь Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийн 20 хувийг сүүлийн 3 сар ханган ажиллаагүй;

7.2.2.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн тухайн сарын хүүгийн орлогыг гэрээний 4.2.2-т заасан хугацаанд сүүлийн 1 сар шилжүүлээгүй;

7.2.3.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг сүүлийн 3 сар үнэн зөв, хугацаанд нь ирүүлээгүй;

7.2.4.Гэрээний заалтуудыг ноцтой зөрчиж байгаа талаар 2 талын холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэл хүргүүлсэн боловч нэг сарын хугацаанд зохих арга хэмжээ аваагүй;

7.2.5.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээлэл ирсэн бол;

7.3.Гэрээний хугацаа дуусгавар болсон, цуцалсан, гэрээний 2.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн тооцоо нийлсэн акт тухай бүр үйлдэнэ.

Найм.Бусад зүйл

8.1.Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

8.2.Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба хадгалуулагч 1 хувь, хадгалагч 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3.Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож тухай бүр шийдвэрлэх бөгөөд гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.4.Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.5.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл

зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

8.6.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр болон батлагдсан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

8.7.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8.8.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний 2.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулж, үүргээ гүйцэтгээгүй хугацаагаар уг үүргийг нөхөн гүйцэтгэнэ.

8.9.Талуудын хооронд гарсан маргааныг харилцан эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

ХАДГАЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НДЕГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА



Б.АЛТАНЦЭЦЭГ

Хаяг: Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Бага тойруу 13/1, Утас:
328030

ХАДГАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГОЛОМТ
БАЙГУУЛЛАГЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

БАНКНЫ
БАНКНЫ



Б.СҮГАР-ЭРДЭНЭ

БАЙГУУЛЛАГЫН
ГАЗРЫН БИЗНЕС
АЖИЛЛАГААНЫ
ЗАХИРАЛ

БАНКНЫ
ХАМТЫН
ХЭЛТСИЙН

А.НЯМСҮРЭН

А.НЯМСҮРЭН

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р
хороо, Сүхбаатарын талбай 5,
Голомт банкны төв байр,
Утас:70111646



МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ

2025 оны 12 дугаар сарын 31

Дугаар *МХ 413/12*
МХ 25-06

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1 хаягт байрлах 9081739 тоот регистрийн дугаартай Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид "Хадгалуулагч" гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 19 хаягт байрлах, 2635534 тоот регистрийн дугаартай Худалдаа хөгжлийн банк (цаашид "Хадгалагч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 454 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг тус тус удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтээр түүний мөнгөн хөрөнгийг хадгалах, түүнийг хадгалуулагчид буцаан төлөх, мөнгөн хөрөнгийн хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мөнгөн хадгаламжийн нөхцөл

2.1. Хадгалуулагч тэтгэврийн нөөц сангийн 51,541,058,000.0 (тавин нэгэн тэрбум таван зуун дөчин нэгэн сая тавин найман мянга) төгрөгийн мөнгөн хадгаламж (цаашид "Хадгаламж" гэх)-ийг 12 сарын хугацаатай (жилийн суурь хоног 365), жилийн 15.11 (арван тав зууны арван нэг) хувийн хүүтэй Худалдаа хөгжлийн банк хадгалуулагчийн хадгаламжийн MN930004000413140491 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар хадгалуулна.

2.2.Энэхүү гэрээгээр тохирсон хүүг мөнгөн хөрөнгө хадгаламжийн дансанд шилжин орсон өдрөөс эхлэн хуримтлуулан тооцож, хадгалагч тухайн сарын хадгаламжийн хуримтлуулсан хүүг сар бүрийн сүүлийн өдөр хадгалуулагчийн 4.2.2-т заасан дансанд бүрэн шилжүүлнэ.

2.3.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө тодорхой дүнгээр зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 өдрийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчид зарлага гарсан сарын зарлагадсан мөнгөн дүнд тооцох хүүг 5 хувиар бууруулж, 10.11 хувиар бодох ба үлдэх хадгаламжийн мөнгөн дүнд энэ гэрээний 2.1-д заасан 15.11 хувиар хүүг хуримтлуулан тооцож олгоно.

2.4.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1, 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хадгалагчийн Монголбанкн дахь 3501004 тоот харилцах данснаас хадгалуулагч үл маргах журмаар суутган авна.

2.5.Гэрээний хугацаанд хадгалагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ буурч хадгалуулагчийн байршуулсан хадгаламжийн дүн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтэрсэн тохиолдолд хадгалагч нь мөнгөн хадгаламжийн зөрүүг хүүгийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар хадгалуулагчаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийн дагуу зарлагын гүйлгээ хийнэ. Энэ нь хадгаламжийн хүү буурах үндэслэл болохгүй.

2.6.Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд талуудын тохирсон хүүгийн хэмжээ хэвээр мөрдөгдөнө.

2.7.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд давхар болон илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ.

Гурав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хадгалуулагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1.1.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээллийн дагуу хадгалуулагч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах;

3.1.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалагчаас шаардах;

3.1.3.Сар бүрийн эцэст хуримтлуулсан хүүгийн мэдээллийг авч байх;

3.1.4.Хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.5.Мөнгөн хадгаламжийн дансны гүйлгээ, үлдэгдэл, хүүгийн бодолтыг тулган шалгах;

3.1.6.Хадгалуулагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь авах;

3.1.7.Хадгалуулагч нь хадгалагч банкны Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авах;

3.1.8.Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацааны эцэст өөрийн мөнгөн хадгаламжийг үл маргах журмаар эргүүлэн авах.

3.2.Хадгалуулагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1.Хадгаламжийн гэрээнд заасан хугацаанд хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулах;

3.2.2.Хадгаламжийн данс ашиглан төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

3.2.3.Хадгалагчийн нууц мэдээллийг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

3.2.4.Хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос 15 хоногийн өмнө хугацааг сунгах эсэх талаар мэдэгдэх;

3.2.5.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх;

3.2.6.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалуулагч үл маргах журмаар эргүүлэн төлөх;

3.2.7.Хадгалуулагчийн албан ёсны нэр, мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээд, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд хадгалагчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх;

3.2.8.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээний улмаас данс андуурч гүйлгээ хийсэн тохиолдолд банканд нэн даруй мэдэгдэх.

Дөрөв. Хадгалагчийн эрх, үүрэг

4.1.Хадгалагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1.Хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалуулагчаас шаардах;

4.1.2.Хадгалуулагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.3.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу данс болон гүйлгээний талаар мэдээллийг шаардах;

4.1.4.Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн хадгалуулагчийн дансанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг төлөхийг шаардах.

4.2.Хадгалагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн 51,541,058,000.0 (тавин нэгэн тэрбум таван зуун дөчин нэгэн сая тавин найман мянга) төгрөгийн мөнгөн хадгаламжийг хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн гэрээний хугацаа дуусгавар болох сүүлийн өдөр 4.2.2-т заасан харилцах дансанд шилжүүлэх;

4.2.2.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хуримтлуулсан хүүгийн орлогыг Худалдаа хөгжлийн банкн дахь хадгалуулагчийн тэтгэврийн нөөц сангийн MN880004000499482803 тоот дансанд сар бүрийн сүүлийн өдөр бүрэн шилжүүлэх;

4.2.3.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв тооцох;

4.2.4.Хадгалагч өөрийн буруугаас үүдэн хийсэн алдаатай гүйлгээг залруулах болон банкны ажилтны буруугаас хадгалуулагчид хохирол учруулсан бол уг хохирлыг нөхөн төлөх;

4.2.5.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн данснаас энэхүү гэрээний 2.3-т заасан нөхцөл үүссэн үед хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ;

4.2.6.Хадгалуулагчийн дансны нууцыг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

4.2.7.Хадгалагч нь дараах мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор хадгалуулагчид ирүүлнэ. Үүнд:

4.2.7.1.Сарын санхүүгийн байдлын тайлан (IFRS-д нийцсэн), орлогын дэлгэрэнгүй тайлан;

4.2.7.2."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам"-ын дагуу Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлт, хувьцааны үнэ ханшийн хэлбэлзэл, олгосон зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, олон улсын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон эсэх зэрэг мэдээлэл;

4.2.7.3.Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг шилжүүлсэн дансны хуулга;

4.2.7.4.Бусад шаардлагатай мэдээлэл.

4.2.8.Хадгалагчийн эцсийн өмчлөгч болон удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд хадгалуулагчид даруй мэдэгдэх;

4.2.9.Хадгалагч нь "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авахыг хадгалуулагчид зөвшөөрнө.

Тав.Талуудын хариуцлага

5.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1-д заасан үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, мөнгөн хадгаламжийн хүүг алдангийн хамт үл маргах журмаар олгоно.

5.2.Хадгалагч энэхүү гэрээний 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, хадгаламжийн хүүг алдангийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар олгоно.

5.3.Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, эсхүл нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна.

5.4.Талууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

Зургаа.Баталгаа

6.1.Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар хадгалагчийн гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан гэрээний нөхцөлүүдийг биелүүлэх тухай байгууллагын шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.

6.2.Хадгалагч нь гэрээний дагуу хариуцлагыг хүлээх хангалттай мөнгөн хөрөнгийн эх үүсвэртэй байна.

6.3.Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрсдийн олж мэдсэн, тухайн байгууллагын холбогдох мэдээ мэдээлэл, баримт бичгийн нууцыг харилцан чанд хадгална.

Долоо.Гэрээ дуусгавар болох, цуцлах

7.1.Энэхүү гэрээний 2.1-д заасан үндсэн хугацаа дууссан, гэрээг 7.2-т заасан үндэслэлээр цуцалснаар дуусгавар болно.

7.2.Гэрээг дор дурдсан нөхцөлөөр хугацаанаас нь өмнө цуцалж, энэ талаар 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Гэрээг цуцлахад энэхүү гэрээний 2.3 дахь хэсэг хамаарахгүй.

7.2.1.Хадгалагч нь Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийн 20 хувийг сүүлийн 3 сар ханган ажиллаагүй;

7.2.2.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн тухайн сарын хүүгийн орлогыг гэрээний 4.2.2-т заасан хугацаанд сүүлийн 1 сар шилжүүлээгүй;

7.2.3.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг сүүлийн 3 сар үнэн зөв, хугацаанд нь ирүүлээгүй;

7.2.4.Гэрээний заалтуудыг ноцтой зөрчиж байгаа талаар 2 талын холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэл хүргүүлсэн боловч нэг сарын хугацаанд зохих арга хэмжээ аваагүй;

7.2.5.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээлэл ирсэн бол.

7.3.Гэрээний хугацаа дуусгавар болсон, цуцалсан, гэрээний 2.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн тооцоо нийлсэн акт тухай бүр үйлдэнэ.

Найм.Бусад зүйл

8.1.Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

8.2.Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба хадгалуулагч 1 хувь, хадгалагч 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3.Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож тухай бүр шийдвэрлэх бөгөөд гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.4.Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.5.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл

зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

8.6.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр болон батлагдсан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

8.7.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8.8.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний 2.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулж, үүргээ гүйцэтгээгүй хугацаагаар уг үүргийг нөхөн гүйцэтгэнэ.

8.9.Талуудын хооронд гарсан маргааныг харилцан эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

ХАДГАЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НДЕГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА



Б.АЛТАНЦЭЦЭГ

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо
Бага тойруу 13/1,
Утас: 328030

ХАДГАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ЖУУЛЧИН САЛБАРЫН ЗАХИРАЛ



Д.БОЛОРЦЭЦЭГ

Хаяг: Сүхбаатар дүүрэг 1-р
хороо, Энхтайвны өргөн чөлөө 19,
Утас: 312362, 331133

БАТЛАВ:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА



Б.БАТЖАРГАЛ



БАТЛАВ:

ХААН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ

Б.ӨРДЭНЭДЭЛГЭР

МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ

2025 оны 12 дугаар сарын 31

Дугаар 2158
MX 25-07

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1 хаягт байрлах 9081739 тоот регистрийн дугаартай Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид "Хадгалуулагч" гэх), нөгөө талаас Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө-6, Стадион Оргил-1, хаягт байрлах, 9016001011 тоот улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай, 2693321 тоот регистрийн дугаартай ХААН банк ХК (цаашид "Хадгалагч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 454 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг тус тус удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтээр түүний мөнгөн хөрөнгийг хадгалах, түүнийг хадгалуулагчид буцаан төлөх, мөнгөн хөрөнгийн хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Мөнгөн хадгаламжийн нөхцөл

2.1.Хадгалуулагч тэтгэврийн нөөц сангийн 92,635,254,000.0 (ерэн хоёр тэрбум зургаан зуун гучин таван сая хоёр зуун тавин дөрвөн мянга) төгрөгийн мөнгөн хадгаламж (цаашид "Хадгаламж" гэх)-ийг 12 сарын хугацаатай (жилийн суурь хоног 365), жилийн 15.11 (арван тав зууны арван нэг) хувийн хүүтэй ХААН банкн дахь хадгалуулагчийн хадгаламжийн MN380005005080022309 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар хадгалуулна.

2.2. Энэхүү гэрээгээр тохирсон хүүг мөнгөн хөрөнгө хадгаламжийн дансанд шилжин орсон өдрөөс эхлэн хуримтлуулан тооцож, хадгалагч тухайн сарын хадгаламжийн хуримтлуулсан хүүг сар бүрийн сүүлийн өдөр хадгалуулагчийн 4.2.2-т заасан дансанд бүрэн шилжүүлнэ.

2.3. Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө тодорхой дүнгээр зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 өдрийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчид зарлага гарсан сарын зарлагадсан мөнгөн дүнд тооцох хүүг 5 хувиар бууруулж, 10.11 хувиар бодох ба үлдэх хадгаламжийн мөнгөн дүнд энэ гэрээний 2.1-д заасан 15.11 хувиар хүүг хуримтлуулан тооцож олгоно.

2.4. Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1, 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хадгалагчийн Монголбанкна дахь 3501005 тоот харилцах данснаас хадгалуулагч үл маргах журмаар суутган авна.

2.5. Гэрээний хугацаанд хадгалагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ буурч хадгалуулагчийн байршуулсан хадгаламжийн дүн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтэрсэн тохиолдолд хадгалагч нь мөнгөн хадгаламжийн зөрүүг хүүгийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар хадгалуулагчаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийн дагуу зарлагын гүйлгээ хийнэ. Энэ нь хадгаламжийн хүү буурах үндэслэл болохгүй.

2.6. Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд талуудын тохирсон хүүгийн хэмжээ хэвээр мөрдөгдөнө.

2.7. Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд давхар болон илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ.

Гурав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

3.1. Хадгалуулагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1.1. Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээллийн дагуу хадгалуулагч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах;

3.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалагчаас шаардах;

3.1.3. Сар бүрийн эцэст хуримтлуулсан хүүгийн мэдээллийг авч байх;

3.1.4. Хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.5. Мөнгөн хадгаламжийн дансны гүйлгээ, үлдэгдэл, хүүгийн бодолтыг тулган шалгах;

3.1.6. Хадгалуулагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь авах;

3.1.7. Хадгалуулагч нь хадгалагч банкны Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авах;

3.1.8. Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацааны эцэст өөрийн мөнгөн хадгаламжийг үл маргах журмаар эргүүлэн авах.

3.2. Хадгалуулагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1.Хадгаламжийн гэрээнд заасан хугацаанд хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулах;

3.2.2.Хадгаламжийн данс ашиглан төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

3.2.3.Хадгалагчийн нууц мэдээллийг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

3.2.4.Хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос 15 хоногийн өмнө хугацааг сунгах эсэх талаар мэдэгдэх;

3.2.5.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх;

3.2.6.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалуулагч үл маргах журмаар эргүүлэн төлөх;

3.2.7.Хадгалуулагчийн албан ёсны нэр, мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээд, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд хадгалагчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх;

3.2.8.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээний улмаас данс андуурч гүйлгээ хийсэн тохиолдолд банканд нэн даруй мэдэгдэх.

Дөрөв. Хадгалагчийн эрх, үүрэг

4.1.Хадгалагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1.Хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалуулагчаас шаардах;

4.1.2.Хадгалуулагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.3.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу данс болон гүйлгээний талаар мэдээллийг шаардах;

4.1.4.Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн хадгалуулагчийн дансанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг төлөхийг шаардах.

4.2.Хадгалагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн 92,635,254,000.0 (ерэн хоёр тэрбум зургаан зуун гучин таван сая хоёр зуун тавин дөрвөн мянга) төгрөгийн мөнгөн хадгаламжийг хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн гэрээний хугацаа дуусгавар болох сүүлийн өдөр 4.2.2-т заасан харилцах дансанд шилжүүлэх;

4.2.2.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хуримтлуулсан хүүгийн орлогыг ХААН банканд дахь хадгалуулагчийн тэтгэврийн нөөц сангийн MN300005005427207472 тоот дансанд сар бүрийн сүүлийн өдөр бүрэн шилжүүлэх;

4.2.3.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв тооцох;

4.2.4.Хадгалагч өөрийн буруугаас үүдэн хийсэн алдаатай гүйлгээг залруулах болон банкны ажилтны буруугаас хадгалуулагчид хохирол учруулсан бол уг хохирлыг нөхөн төлөх;

4.2.5.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн данснаас энэхүү гэрээний 2.3-т заасан нөхцөл үүссэн үед хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ;

4.2.6.Хадгалуулагчийн дансны нууцыг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

4.2.7.Хадгалагч нь дараах мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор хадгалуулагчид ирүүлнэ. Үүнд:

4.2.7.1.сарын санхүүгийн байдлын тайлан (IFRS-д нийцсэн), орлогын дэлгэрэнгүй тайлан;

4.2.7.2."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам"-ын дагуу Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлт, хувьцааны үнэ ханшийн хэлбэлзэл, олгосон зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, олон улсын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон эсэх зэрэг мэдээлэл;

4.2.7.3.Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг шилжүүлсэн дансны хуулга;

4.2.7.4.Бусад шаардлагатай мэдээлэл.

4.2.8.Хадгалагчийн эцсийн өмчлөгч болон удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд хадгалуулагчид даруй мэдэгдэх;

4.2.9.Хадгалагч нь "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авахыг хадгалуулагчид зөвшөөрнө.

Тав. Талуудын хариуцлага

5.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1-д заасан үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, мөнгөн хадгаламжийн хүүг алдангийн хамт үл маргах журмаар олгоно;

5.2.Хадгалагч энэхүү гэрээний 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, хадгаламжийн хүүг алдангийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар олгоно;

5.3.Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, эсхүл нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна;

5.4. Талууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

Зургаа. Баталгаа

6.1.Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар хадгалагчийн гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан гэрээний нөхцөлүүдийг биелүүлэх тухай байгууллагын шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.

6.2.Хадгалагч нь гэрээний дагуу хариуцлагыг хүлээх хангалттай мөнгөн хөрөнгийн эх үүсвэртэй байна.

6.3.Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрсдийн олж мэдсэн, тухайн байгууллагын холбогдох мэдээ мэдээлэл, баримт бичгийн нууцыг харилцан чанд хадгална.

Долоо.Гэрээ дуусгавар болох, цуцлах

7.1.Энэхүү гэрээний 2.1-д заасан үндсэн хугацаа дууссан, гэрээг 7.2-т заасан үндэслэлээр цуцалснаар дуусгавар болно.

7.2.Гэрээг дор дурдсан нөхцөлөөр хугацаанаас нь өмнө цуцалж, энэ талаар 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Гэрээг цуцлахад энэхүү гэрээний 2.3 дахь хэсэг хамаарахгүй.

7.2.1.Хадгалагч нь Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийн 20 хувийг сүүлийн 3 сар ханган ажиллаагүй;

7.2.2.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн тухайн сарын хүүгийн орлогыг гэрээний 4.2.2-т заасан хугацаанд сүүлийн 1 сар шилжүүлээгүй;

7.2.3.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг сүүлийн 3 сар үнэн зөв, хугацаанд нь ирүүлээгүй;

7.2.4.Гэрээний заалтуудыг ноцтой зөрчиж байгаа талаар 2 талын холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэл хүргүүлсэн боловч нэг сарын хугацаанд зохих арга хэмжээ аваагүй;

7.2.5.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээлэл ирсэн бол;

7.3.Гэрээний хугацаа дуусгавар болсон, цуцалсан, гэрээний 2.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн тооцоо нийлсэн акт тухай бүр үйлдэнэ.

Найм. Бусад зүйл

8.1.Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

8.2.Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба хадгалуулагч 1 хувь, хадгалагч 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3.Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож тухай бүр шийдвэрлэх бөгөөд гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.4.Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.5.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага,

төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

8.6.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр болон батлагдсан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

8.7.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8.8.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний 2.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулж, үүргээ гүйцэтгээгүй хугацаагаар уг үүргийг нөхөн гүйцэтгэнэ.

8.9.Талуудын хооронд гарсан маргааныг харилцан эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

ХАДГАЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НДЕГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА


Б.АЛТАНЦЭЦЭГ

Хаяг: Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Бага тойруу 13/1, Утас:
328030

ХАДГАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХААН БАНКНЫ БАЙГУУЛЛАГЫН
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ЗАХИРАЛ


П.АГВААН

Хаяг: Хан-Уул дүүрэг 15-р хороо,
Чингисийн өргөн чөлөө-6,
Стадион Оргил-1,
Утас: 75153333

БАТЛАВ:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

БАТЛАВ:
ТӨРИЙН БАНК ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ө.ГАНТӨР

МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ

2025 оны 12 дугаар сарын 31

Дугаар МХ 25-08

Улаанбаатар хот

08-01/502

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1 хаягт байрлах 9081739 тоот регистрийн дугаартай Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид "Хадгалуулагч" гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Бага тойруу, 7/1-00 хаягт байрлах, 9007001011 тоот улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай, 5341469 тоот регистрийн дугаартай Төрийн банк ХК (цаашид "Хадгалагч" гэх, хамтад нь "Талууд" гэх) нар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 454 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ыг тус тус удирдлага болгон дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтээр түүний мөнгөн хөрөнгийг хадгалах, түүнийг хадгалуулагчид буцаан төлөх, мөнгөн хөрөнгийн хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам болон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Мөнгөн хадгаламжийн нөхцөл

2.1.Хадгалуулагч тэтгэврийн нөөц сангийн 21,966,455,746.52 (хорин нэгэн тэрбум есөн зуун жаран зургаан сая дөрвөн зуун тавин таван мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн мөнгөн хадгаламж (цаашид "Хадгаламж" гэх)-ийг 12 сарын хугацаатай (жилийн суурь хоног 365), жилийн 15.11 (арван тав зууны арван нэг) хувийн хүүтэй Төрийн банкн дахь хадгалуулагчийн хадгаламжийн MN550034106030091413 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаагаар хадгалуулна.



2.2.Энэхүү гэрээгээр тохирсон хүүг мөнгөн хөрөнгө хадгаламжийн дансанд шилжин орсон өдрөөс эхлэн хуримтлуулан тооцож, хадгалагч тухайн сарын хадгаламжийн хуримтлуулсан хүүг сар бүрийн сүүлийн өдөр хадгалуулагчийн 4.2.2-т заасан дансанд бүрэн шилжүүлнэ.

2.3.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө тодорхой дүнгээр зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 өдрийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчид зарлага гарсан сарын зарлагадсан мөнгөн дүнд тооцох хүүг 5 хувиар бууруулж, 10.11 хувиар бодох ба үлдэх хадгаламжийн мөнгөн дүнд энэ гэрээний 2.1-д заасан 15.11 хувиар хүүг хуримтлуулан тооцож олгоно.

2.4.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1, 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хадгалагчийн Монголбанкн дахь 3501034 тоот харилцах данснаас хадгалуулагч үл маргах журмаар суутган авна.

2.5.Гэрээний хугацаанд хадгалагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ буурч хадгалуулагчийн байршуулсан хадгаламжийн дүн банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтэрсэн тохиолдолд хадгалагч нь мөнгөн хадгаламжийн зөрүүг хүүгийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар хадгалуулагчаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийн дагуу зарлагын гүйлгээ хийнэ. Энэ нь хадгаламжийн хүү буурах үндэслэл болохгүй.

2.6.Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд талуудын тохирсон хүүгийн хэмжээ хэвээр мөрдөгдөнө.

2.7.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд давхар болон илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалагч нь хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ.

Гурав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хадгалуулагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.1.1.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээллийн дагуу хадгалуулагч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах;

3.1.2.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалагчаас шаардах;

3.1.3.Сар бүрийн эцэст хуримтлуулсан хүүгийн мэдээллийг авч байх;

3.1.4.Хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

3.1.5.Мөнгөн хадгаламжийн дансны гүйлгээ, үлдэгдэл, хүүгийн бодолтыг тулган шалгах;

3.1.6.Хадгалуулагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь авах;

3.1.7.Хадгалуулагч нь хадгалагч банкны Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авах;

3.1.8.Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацааны эцэст өөрийн мөнгөн хадгаламжийг үл маргах журмаар эргүүлэн авах.

3.2.Хадгалуулагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:



3.2.1.Хадгаламжийн гэрээнд заасан хугацаанд хадгаламжийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулах;

3.2.2.Хадгаламжийн данс ашиглан төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

3.2.3.Хадгалагчийн нууц мэдээллийг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

3.2.4.Хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос 15 хоногийн өмнө хугацааг сунгах эсэх талаар мэдэгдэх;

3.2.5.Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацаанаас өмнө зарлагын гүйлгээ хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хадгалагчид ажлын 7 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх;

3.2.6.Гэрээнд зааснаас бусдаар хадгалуулагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд хадгалуулагч үл маргах журмаар эргүүлэн төлөх;

3.2.7.Хадгалуулагчийн албан ёсны нэр, мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээд, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд хадгалагчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх;

3.2.8.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээний улмаас данс андуурч гүйлгээ хийсэн тохиолдолд банканд нэн даруй мэдэгдэх.

Дөрөв. Хадгалагчийн эрх, үүрэг

4.1.Хадгалагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1.Хадгалагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хадгалуулагчаас шаардах;

4.1.2.Хадгалуулагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

4.1.3.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу данс болон гүйлгээний талаар мэдээллийг шаардах;

4.1.4.Банкны системийн доголдол, техникийн саатлаас үүдэн хадгалуулагчийн дансанд давхар болон илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг төлөхийг шаардах.

4.2.Хадгалагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.2.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 2.1-д заасан тэтгэврийн нөөц сангийн 21,966,455,746.52 (хорин нэгэн тэрбум есөн зуун жаран зургаан сая дөрвөн зуун тавин таван мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн мөнгөн хадгаламжийг хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн гэрээний хугацаа дуусгавар болох сүүлийн өдөр 4.2.2-т заасан харилцах дансанд шилжүүлэх;

4.2.2.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хуримтлуулсан хүүгийн орлогыг Төрийн банкна дахь хадгалуулагчийн тэтгэврийн нөөц сангийн MN380034106030087936 тоот дансанд сар бүрийн сүүлийн өдөр бүрэн шилжүүлэх;

4.2.3.Хадгалагч нь тухайн сарын мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв тооцох;



4.2.4.Хадгалагч өөрийн буруугаас үүдэн хийсэн алдаатай гүйлгээг залруулах болон банкны ажилтны буруугаас хадгалуулагчид хохирол учруулсан бол уг хохирлыг нөхөн төлөх;

4.2.5.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн данснаас энэхүү гэрээний 2.3-т заасан нөхцөл үүссэн үед хадгалуулагчийн төлбөрийн хүсэлтийг үндэслэн зарлагын гүйлгээ хийнэ;

4.2.6.Хадгалуулагчийн дансны нууцыг чандлан хадгалж, хууль журам гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх;

4.2.7.Хадгалагч нь дараах мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор хадгалуулагчид ирүүлнэ. Үүнд:

4.2.7.1.Сарын санхүүгийн байдлын тайлан (IFRS-д нийцсэн), орлогын дэлгэрэнгүй тайлан;

4.2.7.2."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцох, хяналт тавих журам"-ын дагуу Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлт, хувьцааны үнэ ханшийн хэлбэлзэл, олгосон зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, олон улсын итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон эсэх зэрэг мэдээлэл;

4.2.7.3.Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг шилжүүлсэн дансны хуулга;

4.2.7.4.Бусад шаардлагатай мэдээлэл.

4.2.8.Хадгалагчийн эцсийн өмчлөгч болон удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд хадгалуулагчид даруй мэдэгдэх;

4.2.9.Хадгалагч нь "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэх мэдээллийг Монголбанкнаас улирал тутам авахыг хадгалуулагчид зөвшөөрнө.

Тав. Талуудын хариуцлага

5.1.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.1-д заасан үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, мөнгөн хадгаламжийн хүүг алдангийн хамт үл маргах журмаар олгоно;

5.2.Хадгалагч энэхүү гэрээний 4.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги тооцож, хадгаламжийн хүүг алдангийн хамт хадгалуулагчид үл маргах журмаар олгоно;

5.3.Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, эсхүл нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна;

5.4.Талууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

Зургаа.Баталгаа

6.1.Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар хадгалагчийн гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан гэрээний нөхцөлүүдийг биелүүлэх тухай байгууллагын шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан байна.



6.2.Хадгалагч нь гэрээний дагуу хариуцлагыг хүлээх хангалттай мөнгөн хөрөнгийн эх үүсвэртэй байна.

6.3.Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрсдийн олж мэдсэн, тухайн байгууллагын холбогдох мэдээ мэдээлэл, баримт бичгийн нууцыг харилцан чанд хадгална.

Долоо. Гэрээ дуусгавар болох, цуцлах

7.1.Энэхүү гэрээний 2.1-д заасан үндсэн хугацаа дууссан, гэрээг 7.2-т заасан үндэслэлээр цуцалснаар дуусгавар болно.

7.2.Гэрээг дор дурдсан нөхцөлөөр хугацаанаас нь өмнө цуцалж, энэ талаар 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Гэрээг цуцлахад энэхүү гэрээний 2.3 дахь хэсэг хамаарахгүй.

7.2.1.Хадгалагч нь Монголбанкнаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийн 20 хувийг сүүлийн 3 сар ханган ажиллаагүй;

7.2.2.Хадгалагч нь мөнгөн хадгаламжийн тухайн сарын хүүгийн орлогыг гэрээний 4.2.2-т заасан хугацаанд сүүлийн 1 сар шилжүүлээгүй;

7.2.3.Хадгалагч нь энэхүү гэрээний 4.2.7-д заасан мэдээллийг сүүлийн 3 сар үнэн зөв, хугацаанд нь ирүүлээгүй;

7.2.4.Гэрээний заалтуудыг ноцтой зөрчиж байгаа талаар 2 талын холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэл хүргүүлсэн боловч нэг сарын хугацаанд зохих арга хэмжээ аваагүй;

7.2.5.Хадгалагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдал алдагдсан талаарх эрх бүхий байгууллагын мэдээлэл ирсэн бол;

7.3.Гэрээний хугацаа дуусгавар болсон, цуцалсан, гэрээний 2.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн тооцоо нийлсэн акт тухай бүр үйлдэнэ.

Найм. Бусад зүйл

8.1.Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

8.2.Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба хадгалуулагч 1 хувь, хадгалагч 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3.Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож тухай бүр шийдвэрлэх бөгөөд гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.4.Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.5.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага,



төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

8.6.Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр болон батлагдсан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

8.7.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

8.8.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний 2.2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулж, үүргээ гүйцэтгээгүй хугацаагаар уг үүргийг нөхөн гүйцэтгэнэ.

8.9.Талуудын хооронд гарсан маргааныг харилцан эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

ХАДГАЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НДЕГ-ЫН САНХҮҮ БҮРТГЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА



Б.АЛТАНЦЭЦЭГ

Хаяг: Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Бага тойруу 13/1, Утас:
328030

ХАДГАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТӨРИЙН БАНКНЫ БИЗНЕС
ХАРИУЦСАН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТЭРГҮҮН ОРЛОГЧ



Д.СУГАР

ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Э.БАТБАЯР

БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ
ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ
ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ

Б.ЖАДАМБАА

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр
хороо, Бага тойруу, 7/1-00,
Утас: 310103

